СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
2016 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЙЛБАР

2016.10.05

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны төсөв 31,0 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд үүнээс 3 дугаар улирлын байдлаар 23,9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг авч, 18,3 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарлаа.

Үндсэн үйл ажиллагааны зардал: Хорооны үндсэн үйл ажиллагааны санхүүжилт 556,3 сая төгрөг батлагдаж, 505,9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч зардлын зүйл хэтрээгүй байна. Зардлыг зүйл ангиар нь задалбал:

-Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал – 306,6 сая төгрөг /91,9%/

-НДШ – 33,7 сая төгрөг /91,9%/

-Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал – 3,9 сая төгрөг /33,1%/

-Хангамж, бараа материалын зардал-28,9 сая төгрөг /91,1%/

-Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ-131,9 сая төгрөг /98,1%/

Нийт гүйцэтгэл 90,9 хувьтай гарсан байна.

Төсвийн гүйцэтгэлээс харахад цалин хөлс, нэмэгдэл урамшуулал /26,9 сая/, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал /7,9 сая/ хангамж, бараа материалын зардал /2,8 сая/, томилолтын зардал /3,4 сая/, бараа үйлчилгээний бусад зардал /2,6 сая/ зэрэг зардлууд хэмнэлттэй гарсан байна. Үүнд:

1.Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал: Ажлын албаны зарим ажилтнуудын зэрэг дэв, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл өгөх хугацаа болоогүйгээс цалин, НДШ-ийн зардал хэмнэгдэж үлдсэн.

2. Томилолт, зочны зардал: Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны баримт бичгийн хадгалалт, хамгаалалттыг шалгах ажлын хугацаа болоогүй тул зардал хэмнэгдсэн.

Мэдээлэл сурталчилгааны зардал: Энэ зардлын санхүүжилт хийгдээгүй тул хэмнэгдсэн.

УИХ-ын сонгуулийн зардал: УИХ-ын сонгуулийн зардал 14,9 тэрбум төгрөг батлагдаж, 14,5 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарлаа. Сонгуулийн тухай хуульд өөрчлөлт орж УИХ-ын сонгуулиар гадаад улсад байгаа сонгогчийн санал авах ажиллагаа болоогүй тул 427,2 сая төгрөгийн хэмнэлт гарсан.

Орон нутгийн сонгууль: Орон нутгийн сонгуулийн зардал 13,9 тэрбум төгрөг батлагдаж, 7,0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг авч, 3,3 тэрбум төгрөгийн

гүйцэтгэлтэй гарлаа. Сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой зарим ажлуудын төлбөр хийх хугацаа болоогүй тул хэмнэлттэй харагдаж байна.

УИХ-д суудалтай намуудад олгох дэмжлэг: Улс төрийн намын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасны дагуу Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016.09.30-ны өдрийн 276 дугаар тогтоол гарч шийдвэрлэгдсэн тул шилжүүлгийг 10 дугаар сард хийхээр болсон тул хэмнэлттэй харагдаж байна.

Нийт төсвийн гүйцэтгэл 18,3 тэрбум төгрөг буюу 76,6 хувьтай гарч байна

Ахлах референт Ж.Оюунгэрэл